



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/347

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 1 нэгж талбарын газар эзэмшигч иргэний эзэмшил газрыг зориулалтын дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/476 дугаар захирамжийн С.Дашцэрэнтэй холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100745

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 14 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /M <sup>2</sup> /	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /M <sup>2</sup> /	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	С.Дашцэрэн	ЙВ57101510	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	1400	Д.Одончимэг	ЙВ87030821	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	700	12 дугаар баг, Шинэ Арвайхээр-2, 219а тоот	10 жил
						ЙВ57101510		700		12 дугаар баг, Шинэ Арвайхээр-2, 219 тоот